



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
БШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БШУ	Боловсрол шинжлэх ухаан

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3.Аудитын тайлан	15
3.1. Ерөнхий зүйл	15
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4. Материаллаг байдал.....	16
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Албан шаардлага	21
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/110-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

ЕРӨӨ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.БОЛОРТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,378,849.13	154,229,579.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	21,000.00	2,653,242.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	2,653,242.00
33500	Бусад авлага	21,000.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	21,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	111,357,849.13	151,576,337.18
35100	Түүхий эд материал	4,136,309.02	20,307,409.02
35110	Тусгай зориулалттай материал	3,636,309.02	20,307,409.02
35130	Эм боох материал	500,000.00	0.00
35400	Хангамжийн материал	103,311,540.11	131,268,928.16
35420	Аж ахуйн материал	67,681,998.34	67,681,998.34
35430	Сэлбэг хэрэгсэл	750,000.00	750,000.00
35450	Барилгын засварын материал	0.00	13,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	34,879,541.77	49,836,929.82
35600	Мал амьтад	3,910,000.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,014,843,780.33	1,066,089,445.67
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,014,843,780.33	1,066,089,445.67
39200	Биет хөрөнгө	932,861,557.73	977,538,889.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	751,891,769.00	816,891,769.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,960,301.11)	(158,269,543.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,610,500.00	18,610,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,597,569.18)	(18,610,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	211,497,770.40	244,194,260.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,324,169.80)	(82,200,521.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	97,836,110.30	101,409,746.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(46,998,067.52)	(52,720,230.21)
39209	Зам, гүүрийн байгууламж	16,887,852.00	16,887,852.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,895,800.00)	(7,895,800.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	66,513,854.00	66,513,854.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,120,000.16)	(8,792,106.96)
39217	Ном	41,519,609.80	41,519,609.80
39300	Биет бус хөрөнгө	81,982,222.60	88,550,555.96
39301	Программ хангамж	1,818,000.00	8,803,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(845,777.40)	(1,262,444.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	81,010,000.00	81,010,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,126,222,629.46	1,220,319,024.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,173,103.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,173,103.00	0.00
41300	Өглөг	1,173,103.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,173,103.00	0.00
41400	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,125,049,526.46	1,220,319,024.85
51	Засгийн газрын хувь оролцоо	1,125,049,526.46	1,220,319,024.85

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	570,012,254.67	570,012,254.67
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	570,012,254.67	570,012,254.67
51200	Хуримтлагдсан үр дүн	347,450,514.42	442,720,012.81
51210	Өмнөх үеийн үр дүн	290,632,080.06	347,450,514.42
51220	Тайлант үеийн үр дүн	56,818,434.36	95,269,498.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	207,586,757.37	207,586,757.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,126,222,629.46	1,220,319,024.85

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,198,196,273.29	1,315,149,714.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,230,055.29	112,848,614.68
120	Нийтлэг татварын бус орлого	73,474,929.27	112,848,614.68
120001	Хувьцааны ногдол ашиг	71,230,055.29	112,848,614.68
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,244,873.98	89,115,126.63
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,244,873.98	23,733,488.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,126,966,218.00	1,202,301,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	972,577,700.00	963,872,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	972,577,700.00	963,872,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,021,000.00	5,605,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	1,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	648,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	521,000.00	3,932,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	153,367,518.00	232,823,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	153,367,518.00	232,823,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,141,377,838.93	1,219,880,216.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,141,377,838.93	1,219,880,216.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,049,024,458.93	1,159,548,160.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	725,262,769.00	736,408,757.00
210101	Үндсэн цалин	624,210,416.00	475,841,512.00
210102	Нэмэгдэл	43,747,058.00	216,752,245.00
210104	Урамшуулал	57,305,295.00	43,815,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,218,985.00	91,760,742.00
210201	Тэтгэврийн даатгал	65,293,453.00	63,654,735.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,395,821.00	7,092,117.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,778,824.00	5,673,775.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,340,988.00	1,394,491.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,409,899.00	13,945,624.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,198,818.00	218,823,800.00
210301	Гэрэл, цахилгаан	11,410,318.00	21,236,908.00
210302	Түлш, халаалт	130,702,800.00	197,586,892.00
210303	Цэвэр, бохир ус	1,085,700.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,543,880.00	16,792,100.00
210401	Бичиг хэрэг	598,300.00	1,793,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	2,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	328,000.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	232,900.00	4,018,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,568,580.00	565,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,316,100.00	7,264,200.00
2105	Нормативт зардал	16,809,595.00	25,107,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	324,700.00	1,418,100.00
210502	Хоол, хүнс	14,099,895.00	22,418,100.00

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,385,000.00	1,271,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,419,900.00	6,071,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,243,500.00	120,000.00
210602	Тавилга	4,488,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	177,000.00	0.00
210604	Урсгал засвар	18,999,400.00	5,951,300.00
2107	Томилолт, зочны зардал	360,400.00	664,200.00
210702	Дотоод албан томилолт	360,400.00	664,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,080,800.00	3,308,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,360,800.00	2,300,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,129,311.93	60,611,461.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	378,970.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,218,300.00	3,602,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,532,041.93	57,009,461.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,353,380.00	60,332,056.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,487,990.00	34,489,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	3,910,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,487,990.00	30,079,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,865,390.00	25,842,656.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,865,390.00	25,842,656.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	56,818,434.36	95,269,498.39
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	56,818,434.36	95,269,498.39

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,131,081,093.00	1,202,322,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,131,081,093.00	1,202,322,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	972,577,700.00	963,872,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	972,577,700.00	963,872,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,135,875.00	5,626,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	1,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	648,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,635,875.00	3,953,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	153,367,518.00	232,823,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	153,367,518.00	232,823,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,108,231,093.00	1,183,182,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,231,093.00	1,183,182,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,018,335,273.00	1,126,760,044.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	725,262,769.00	739,061,999.00
210101	Үндсэн цалин	624,210,416.00	476,737,776.00
210102	Нэмэгдэл	43,747,058.00	218,509,223.00
210104	Урамшуулал	57,305,295.00	43,815,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,095,881.00	92,933,845.00
210201	Тэтгэврийн даатгал	64,170,349.00	64,828,838.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,395,821.00	7,092,117.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,778,824.00	5,673,775.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,340,988.00	1,394,491.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,409,899.00	13,944,624.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,198,818.00	218,823,800.00
210301	Гэрэл, цахилгаан	11,410,318.00	21,236,908.00
210302	Түлш, халаалт	130,702,800.00	197,586,892.00
210303	Цэвэр, бохир ус	1,085,700.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,219,175.00	18,770,100.00
210401	Бичиг хэрэг	533,300.00	1,793,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	2,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	328,000.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	232,900.00	4,018,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,262,100.00	1,735,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,362,875.00	8,072,600.00
2105	Нормативт зардал	16,333,230.00	30,084,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	824,700.00	918,100.00
210502	Хоол, хүнс	13,123,530.00	22,418,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,385,000.00	6,748,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,904,900.00	19,511,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,905,500.00	560,000.00
210602	Тавилга	4,488,000.00	0.00
210604	Урсгал засвар	18,999,400.00	18,951,300.00
2107	Томилолт, зочны зардал	360,400.00	664,200.00

210702	Дотоод албан томилолт	360,400.00	664,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,080,800.00	3,308,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,360,800.00	2,300,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,879,300.00	3,602,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,379,300.00	3,602,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,895,820.00	56,422,056.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,009,430.00	30,579,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,009,430.00	30,079,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,000.00	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,000.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,865,390.00	25,842,656.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,865,390.00	25,842,656.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,850,000.00	19,140,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,850,000.00	19,140,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,850,000.00	19,140,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,850,000.00	19,140,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,850,000.00	19,140,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,850,000.00)	(19,140,000.00)

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	290,632,080.06	1,068,231,092.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	290,632,080.06	1,068,231,092.10
9	Тайлант үеийн үр дүн			56,818,434.36	56,818,434.36
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	347,450,514.42	1,125,049,526.46
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	347,450,514.42	1,125,049,526.46
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	347,450,514.42	1,125,049,526.46
19	Тайлант үеийн үр дүн			95,269,498.39	95,269,498.39
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	570,012,254.67	207,586,757.37	442,720,012.81	1,220,319,024.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,196,695,800.00	1,196,695,800.00	0.00	100.00%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,196,695,800.00	1,177,555,800.00	19,140,000.00	98.40%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,163,481,300.00	1,121,133,744.00	42,347,556.00	96.36%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	750,394,300.00	739,061,999.00	11,332,301.00	98.49%
210101	Үндсэн цалин	533,683,300.00	476,737,776.00	56,945,524.00	89.33%
210102	Нэмэгдэл	172,896,000.00	218,509,223.00	(45,613,223.00)	126.38%
210104	Урамшуулал	43,815,000.00	43,815,000.00	0.00	100.00%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,755,000.00	92,933,845.00	3,821,155.00	96.05%
210201	Тэтгэврийн даатгал	67,267,100.00	64,828,838.00	2,438,262.00	96.38%
210202	Тэтгэмжийн даатгал	7,372,000.00	7,092,117.00	279,883.00	96.20%
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,897,600.00	5,673,775.00	223,825.00	96.20%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,474,400.00	1,394,491.00	79,909.00	94.58%
210205	Эрүүл мэндийн даатгал	14,743,900.00	13,944,624.00	799,276.00	94.58%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	218,823,800.00	218,823,800.00	0.00	100.00%
210301	Гэрэл, цахилгаан	20,096,300.00	21,236,908.00	(1,140,608.00)	105.68%
210302	Түлш, халаалт	197,247,500.00	197,586,892.00	(339,392.00)	100.17%
210303	Цэвэр, бохир ус	1,480,000.00	0.00	1,480,000.00	0.00%
2104	Хангамж, бараа материалын зардал	13,143,800.00	13,143,800.00	0.00	100.00%
210401	Бичиг хэрэг	568,400.00	1,368,900.00	(800,500.00)	240.83%
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	2,550,000.00	(1,250,000.00)	196.15%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,033,800.00	600,000.00	1,433,800.00	29.50%
210404	Ном, хэвлэл	714,700.00	98,000.00	616,700.00	13.71%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,479,300.00	1,479,300.00	0.00	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,047,600.00	7,047,600.00	0.00	100.00%
2105	Нормативт зардал	38,138,400.00	30,084,300.00	8,054,100.00	78.88%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	918,100.00	918,100.00	0.00	100.00%
210502	Хоол, хүнс	30,472,200.00	22,418,100.00	8,054,100.00	73.57%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,748,100.00	6,748,100.00	0.00	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,651,300.00	19,511,300.00	19,140,000.00	50.48%
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,200,000.00	560,000.00	18,640,000.00	2.92%
210602	Тавилга	500,000.00	0.00	500,000.00	0.00%
210604	Урсгал засвар	18,951,300.00	18,951,300.00	0.00	100.00%
2107	Томилолт, зочны зардал	664,200.00	664,200.00	0.00	100.00%
210702	Дотоод албан томилолт	664,200.00	664,200.00	0.00	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,308,500.00	3,308,500.00	0.00	100.00%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,300,500.00	2,300,500.00	0.00	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00	0.00	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,602,000.00	3,602,000.00	0.00	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,602,000.00	3,602,000.00	0.00	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,214,500.00	30,579,400.00	2,635,100.00	92.07%
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,214,500.00	30,579,400.00	2,635,100.00	92.07%

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,714,500.00	30,079,400.00	2,635,100.00	91.95%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	25,842,656.00	0.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	25,842,656.00	0.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	19,140,000.00	(19,140,000.00)	
220001	Барилга байгууламж	0.00	19,140,000.00	(19,140,000.00)	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,196,695,800.00	1,196,695,800.00	0.00	100.00%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	963,872,000.00	963,872,000.00	0.00	100.00%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	963,872,000.00	963,872,000.00	0.00	100.00%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	232,823,800.00	232,823,800.00	0.00	100.00%
320001	Орон нутгийн төсвөөс	232,823,800.00	232,823,800.00	0.00	100.00%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	0.00	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	914.00	906.00	8.00	99.12%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	64.00	64.00	0.00	100.00%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	64.00	64.00	0.00	100.00%

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /				
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,626,300.00	-5,626,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,626,300.00	-5,626,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,626,300.00	-5,626,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5,626,300.00	-5,626,300.00
210401	Бичиг хэрэг		424,500.00	-424,500.00
210404	Ном, хэвлэл		3,920,800.00	-3,920,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,025,000.00	-1,025,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		5,626,300.00	-5,626,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,626,300.00	-5,626,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,025,000.00	-1,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		648,000.00	-648,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,953,300.00	-3,953,300.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн / цаашид *Ерөө сумын ерөнхий боловсролын сургууль гэх*/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Батцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөө сумын ерөнхий боловсролын сургууль нь “*Сургуулийн насны хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад багш, эцэг эх, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна*” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,141,377.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,413.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,989.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94,096.4 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	21.0	2,653.2	2,632.2

Бараа материал	111,357.8	151,576.4	40,218.6
Үндсэн хөрөнгө	1,014,843.8	1,066,089.4	51,245.6
Нийт хөрөнгө	1,126,222.6	1,220,319.0	94,096.4
Өр төлбөр	1,173.1		(1,173.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,125,049.5	1,220,319.0	95,269.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,126,222.6	1,220,319.0	94,096.4

Авлага дансны үлдэгдэл 2,653.2 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас суутгасан ХХОАТ-ыг илүү төлснөөс нь шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 40,218.6 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 18,924.4 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1,708.7 мянган төгрөгийн, аймгийн БСГ-аас 586.2 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, Ерөө сумын ЗДТГ-аас 2,514.1 мянган төгрөгийн бичгийн нэг удаагийн хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 98,610.8 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, сургуулийн захирлын 2021 оны 12 дугаарын 17-ны өдрийн А/47 дугаар тушаалаар 3,910.0 мянган төгрөгийн мал акталж данснаас хассан, 78,215.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 108,255.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь “Баянгол” сангийн хөрөнгө оруулалтаар сургуулийн хичээлийн нэгдүгээр байрны дээврийн шинэчлэн засаж 65,000.0 мянган төгрөгөөр капиталжуулсан, Ерөө сумын ЗДТГ-аас 890.0 мянган төгрөгийн ус шүүгч, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 5,213.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, БШУЯ-наас 18,012.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 19,140.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,173.1 мянган төгрөгөөр буурсан нь НДШ-ийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,220,319.0 мянган төгрөг болж 95,269.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 114,708.6 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 72,764.4 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн нь түлш халаалтын зардал, хоол хүнсний зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, өссөн нь голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,436,035.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Сургуулийн сургалтын үйл ажиллагаа нь таним болон танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,196,295.8 мянган** төгрөгийн төсөв баталснаас 963,472.0 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 232,823.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын 963,872.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 232,823.8 мянган төгрөгийн санхүүжилт, өмнөх оны авлага 21.0 мянган төгрөгийн зэрэг нийт 1,196,716.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **1,170,874.2** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 25,842.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,170,842.6 мянган төгрөг буюу 97.8 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 15,153.4 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 8,054.1 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал 2,635.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 256.0 мянган төгрөг, үнэлгээний шалгалтын зардалд 392.0 мянган төгрөг, түрээсийн номын 3,923.3 мянган төгрөг, Ерөө сумын ЗДТГ-с ариутгалын зардалд 1,025.0 мянган төгрөгийн зэрэг нийт 5,596.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан, түрээсийн номын орлого 3,932.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн*

дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бус, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.7.3 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 71,376.8 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 21 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 122 мэдээллийг бүрэн оруулж, 27 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Ерөө сумын ерөнхий боловсролын сургуульд 1,196,295.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,170,842.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.2 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 43,255.0 мянган төгрөгийн шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **22,832.9** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,653.2 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,230.9 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,653.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэн, 16,295.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд санхүүгийн тайланд 2,653.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг авлагыг тусгаагүй байсныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр захирал Л.Болортуяад ТАХ-ны нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг 5 хувиар илүү тооцож, 125.4 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас ажилласан цагийн хөлсийг буруу тооцож, 2 багшид 172.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Танхимын хичээл сургалтын үйл ажиллагаа зогссон үед багш, ажиллагсад 933.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 АЛБАН ШААРДЛАГА

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **2,653.2** мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн ба “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд **3,909.4** мянган төгрөгийг цалингийн зардлаас санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 12,386.2 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт Шилэн дансны цахим хуудсанд 27 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7-д гэсэн заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөө сумын Ерөнхий боловсролын сургууль	8	22,832.9	1	2,653.2	3	1,230.9	1	2,653.2	3	16,295.6